



VIII/2021


Тархаасан: 2021 оны 9 дүгээр сарын 10



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх сараас 0.1 хувиар буурлаа.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 8 дугаар сард урьдчилсан гүйцэтгэлээр 163.6 болж, үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өсөж, өмнөх сараас 0.1 хувиар буурсан байна.

ЗУРАГ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, (2015=100), сараар, хувь



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 21.0 хувиар (нүүрс олборлолтын үнэ 8.1 хувь, газрын тос, олборлолтын үнэ 67.9 хувь, металлын хүдэр олборлолтын үнэ 10.3 хувь, бусад ашигт малтмал олборлолтын үнэ 13.0 хувь) өссөнөөс шалтгаалсан байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2021 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.1 хувиар буурахад уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.7 хувиар (газрын тос, олборлолтынх 4.4 хувь, бусад ашигт малтмал олборлолтын үнэ 0.3 хувь) буурснаас голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКСИЙН ӨӨРЧЛӨЛТӨД ДЭД САЛБАРУУДЫН ОРОЛЦОО, нэгж, хувиар жил бүрийн 8 дугаар сарын байдлаар

Дэд салбар	2019		2020		2021	
	хувь	нэгж хувь	хувь	нэгж хувь	хувь	нэгж хувь
Ерөнхий индекс	0.8	100.0	3.4	100.0	17.4	100.0
Уул уурхай, олборлолт	-0.1	-10.9	1.7	50.8	16.6	95.7
Боловсруулах үйлдвэрлэл	1.1	132.1	0.8	22.5	0.6	3.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	-0.3	-33.1	0.9	26.6	0.2	0.9
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.1	11.9	0.0	0.1	0.0	0.0

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өсөхөд уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэгчийн үнэ 16.6 нэгж, боловсруулах үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.6 нэгж, цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.2 нэгжээр нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС, дэд салбараар, хувиар, 2021 оны 8 дугаар сард

Дэд салбар	Нийт жин 2015=100	<u>2021* VIII</u> 2015	<u>2021* VIII</u> 2020 VIII	<u>2021* VIII</u> 2021 VII
		Ерөнхий индекс	100.0	163.6
Уул уурхай, олборлолт	77.9	171.3	121.0	99.3
Боловсруулах үйлдвэрлэл	14.6	136.4	104.3	100.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6.7	135.2	102.5	107.4
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.8	147.3	100.2	100.0

Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэгчийн үнийн индекс (ҮҮИ): Тухайн үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн болон худалдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин: Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

Тооцох аргачлал:

Үйлдвэрлэгчийн үнийн индексийн тооцоонд Ласпейрсийн үнийн индексийг хэрэглэнэ. Үүнд:

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейрсийн үнийн индекс

t – Тайлант үе

0 – Суурь үе

p_t^i – i барааны тайлант үеийн үнэ

p_0^i – i барааны суурь үеийн үнэ

q_0^i - i барааны суурь үеийн худалдан авсан тоо



Эх үүсвэр: ҮСХ, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал,
Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Үнийн
статистикийн хэлтсийн статистикч Б.Энхтүвшин
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212